

Монгол хөдрөгийн түүхэн хөгжлийн тойм

Энхжаргалын Цэцгээ^{1,*}
Пүрэвсүхийн Байгалмаа²

¹Соёл урлагийн их сургуулийн Дүрслэх урлагийн академи, Улаанбаатар, Монгол Улс

²Г.Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музей, Улаанбаатар, Монгол Улс

¹ORCID: <https://orcid.org/0009-0008-2301-8656>

*Холбоо барих зохиогч: etsetsgeee@gmail.com

Хураангуй: Хөдрөг урлал нь дэлхий дахинд өргөн тархаж хөгжлийнхөө оргил үедээ байгаа ч манай улсын хувьд дөнгөж хөгжиж эхэлж буй мэт ойлголт байдгаас ер нь бидэнд хөдрөгийн түүх байдаг уу гэсэн асуулт урган гардаг. Хөдрөгийн олон улсын түүхийг судлах явцад Монголоос олдсон биет олдвор нь НТӨ III-I зууны үед хамаарах Төв аймгийн Батсүмбэр сумын нутаг Ноён уулан дахь хүннүгийн язгууртны булшнаас илэрсэн хүннү ширмэлийг гэж үздэг болох нь гаднын судлаачдын бүтээлүүдэд дурдагддаг. Хэдийгээр хүннү ширмэл нь шинэ үеийн хөдрөгөөс зарим талаараа өөр байдаг ч хөдрөгийн үндсэн тодорхойлолтод нийцсэн байдаг тул анхны олдворт зүй ёсоор тооцдог байна. Харин зүйж хийгдсэн анхны олдвор нь Юань гүрний үед хамааралтай байдаг. Энэ талаар түүхчилсэн, харьцуулсан судалгаа дутмаг байна.

Дээрх манай улстай хамаарал бүхий хөдрөгийн олдворуудын онцлог байдал, хийх аргачлал зэргийг судлан илрүүлж, дэлхийн хөдрөгийн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсан байж болохыг баримтжуулах нь тодорхой ач холбогдолтой төдийгүй хөдрөг бол манай язгуур гар урлал, өв соёл гэж үзэн цаашдаа олон улсын тавцанд монгол хөдрөгтэй холбоотой судалгааг эхлүүлэх боломжтой.

Энэ удаагийн судалгаагаар манай улсаас олдсон түүхэн цаг үеүдэд холбогдох олдворуудаас монгол хөдрөгийн дурсгалыг илрүүлснээр монгол хөдрөг түүнд хамаарах зүйлс нь өөрийн гэсэн онцлог шинж чанартай төдийгүй түүхэн хөгжлийн үеүддээ хэрхэн хувьсан өөрчлөгдөж өнөөдрийг хүрсэн талаар судлан, цаашид монгол хөдрөгт соёлын үнэ цэнийг бий болгож, уламжлалт урлагийн төрөл зүйлийн нэгд зүй ёсоор тооцож болохуйц үр дүнд хүргэлээ.

Түлхүүр үгс: *хүннү ширмэл, ширмэл хөдрөг, зүймэл, даавуун урлал, соёлын өв, урлаг*

A Historical development of Mongolian quilt

Tsetsgee Enkhjargal^{1,*}
Baigalmaa Purevsukh²

¹ Academy of Fine Arts, Mongolian National University of Arts and Culture,
Ulaanbaatar, Mongolia

² The Fine Arts Zanabazar Museum, Ulaanbaatar, Mongolia

¹ ORCID: <https://orcid.org/0009-0008-2301-8656>

* Corresponding author: etssetsgeee@gmail.com

Abstract: Although the art of quilting has spread worldwide and is at the peak of its development, the assumption that it is only beginning to develop in our country gives a rise to the question: “Do we have any history of quilting?” According to the international history of quilting, the red carpet from the tombs of the aristocracy of the Xiongnu at the Noin-Ula burial site located in Batsumber sum of Tov Province is regarded by researchers abroad as the earliest tangible evidence of quilting. This Hunnu carpet is somewhat different from modern-day quilts, however, conforms to the basic definition of the quilt. Moreover, the earliest finding of patchwork is among artifacts of the Yuan dynasty, a successor to the Mongol Empire. Revealing the defining characteristics of and technology behind these traditional handicrafts of our own country may open a possibility to study Mongol quilting internationally as a valuable part in the historical development of quilting. This research will clarify the uniqueness and evolution of Mongol quilting. The vision of this research is to define Mongol quilting as one of our traditional arts by adding cultural value to the quilting in contemporary Mongolia.

Keywords: *Hunnu quilting, quilting, patchwork, textile art, cultural heritage*

Оршил

Дэлхий дахинд хөдрөг урлал нь урлагийн бие даасан төрөл болж хурдацтай хөгжиж ирсэн нь сүүлийн 50 жилийн хөдрөг урлалын түүхээс тодорхой харагддаг. Хөдрөг нь тухайн улсынхаа соёл урлаг, эдийн засаг, аялал жуулчлалд тодорхой ашиг тусыг үзүүлж байдаг нь олон улсын хөдрөгийн үзэсгэлэнгүүд, энэ төрлийн тусгай аялал жуулчлал, төрөлжсөн музей, хөдрөг хийхэд шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл болон даавууны үйлдвэрлэл, төрөл бүрийн сургалт, ном сэтгүүл, олон нийтийн сувгууд зэрэг үзүүлэлтүүдээр илэрч байдаг.

Хөдрөг урлалын анхны хувилбар (баримал) нь 1903 онд Абидос дахь Осирисын сүмээс олдсон одоогоос 3400 жилийн өмнөх үед хамаарах зааны ясан сийлбэр дээрх Египетийн анхны эзэнт гүрний хааны өмссөн ширмэл мэт харагдах нөмрөгийг (The British Museum 1980) гэж үздэг. Энэ нь хөдрөгийн олдвор гэхээсээ илүү зааны ясан баримлын олдвор тул шууд хөдрөгөн хувцас гэж тодорхойлсон байгаа нь зарим нэг талаараа учир дутагдалтай мэт санагдлаа. Жишээ нь, тухайн нөмөрсөн даавууны хээг сийлсэн байж болохыг давхар дурдах хэрэгтэй байна.



Зураг 1. Грекийн хаан. Зааны ясан сийлбэр. НТӨ 1400 он. Британий музей. Англи

Анхны биет олдвор нь хүннүгийн үед холбогдох бөгөөд даавуугаар өнгөлсөн эсгий ширмэл (Carolyn Ducey, International Quilt Study Center 2011) юм. Ингэж үзэх гол үндэслэл нь хүннүгийн ширмэлийг урлахдаа эсгий ширмэл болон зээгт урлалыг хослуулсан байдгийн зэрэгцээ гадуур ба дотуур хүрээ, тэдгээрийн хооронд геометрийн дүрсүүд, амьтны загварт урлалын дүрслэлүүдийг урласан арга техник, давхарлага байдал зэрэг нь зүймэл урлалын шинжийг агуулж байдагт оршино. Монголчууд эсгийгээ олон янзаар ширж хэрэглэдэг байсны нэг илрэл нь эртний цэргүүдийн хөө хуягийн дотор талт зөөллөх, дулаалах зориулалтаар өмсдөг байсан олбог буюу охор хүрэм юм. Энэхүү олбог гэх цэргийн хуягийн нэршлийг Х.Нямбуу (2002) Жангар туулиар жишээлэн тодорхой дурдсан нь эсгий ширмэл эд зүйлсийг зүймэл урлалын олон талт шинжийг агуулж бүтээж байсны тодорхой гэрч юм. Харин XI зууны сүүл XII зууны эхээр европт цэргүүд нь дээрх хувцаснаас санаа аван хэрэглэж иржээ.

Э.Цэцгээ, Б.Шийлэгмаа нар (2017) XVI зууны үеэс Италид хөдрөгийг орны бүтээлэг хэлбэрээр түлхүү хэрэглэж байсан бол XVII зууны сүүлээс Англи, XVIII зууны үеэс Америкт түгэн дэлгэрсэн талаар улс орон бүрээр дэлгэрэнгүй бичжээ.

1970-аад оны үеэс эхлэн хөдрөгийг дүрслэх урлагийн нэгэн төрөл хэмээн үзэж, Америк, Англи зэрэг улсад урлаачдын үзэсгэлэнгүүд зохион байгуулагдаж, тухайн үеийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд дээр хөдрөгийн талаар судлаач, сэтгүүлч, дизайнеруудын илтгэл, бичвэрүүд гарч эхэлсэн (Cindy Joan Brick 2019). Анхны үзэсгэлэн нь 1971 онд “Америк хөдрөг дэх хийсвэрлэлийн дизайн” нэртэйгээр Нью-Йорк дахь Уитнигийн Америкийн урлагийн музейд зохион байгуулагдаж байв. Энэ үеэс эхлэн хөдрөгийг бие даасан урлагийн нэгэн төрөл зүйлд авч үзэн олон улсыг хамарсан үзэсгэлэн арга хэмжээ, уулзалт семинар, сургалт судалгааны ажлууд маш эрчимтэйгээр зохион байгуулагдсаар өнөөдрийг хүрчээ. Түүнчлэн хийгдэж буй арга барилын хувьд уламжлалт загварууд илүү нарийн төвөгтэй

болохын хэрээр нөгөө талаас уламжлалт хэв маягийг эвдсэн орчин цагийн текстил урлагийн төлөөлөл болохуйц уран дүрслэл бүхий төрөл нь хөдрөг урлаг (“Quilt art”) нэрийн дор хөгжиж байна.

Хөдрөг нь дэлхийн ихэнх улс оронд түгэн дэлгэрч, орчин үеийн урлагийн төлөөлөл болохын зэрэгцээ түүнийг дагасан бараа үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ огцом хөгжиж, эдийн засаг, аялал жуулчлалын шинэ сувгууд бий болж, хэрэглээний хувьд гэр ахуй, хувцас загварт ихээхэн дэлгэрэн, уран бүтээлчид, дизайнеруудын өөрсдийгөө сорих талбар болсон. GITNUX компанийн гаргасан 2022 оны судалгаа болох зах зээлийн өгөгдөлд суурилсан тайланд дэлхийн хөдрөгийн зах зээлийн үйлдвэрлэл нь 6.3 тэрбум америк долларт хүрч байгаа бөгөөд энэ үзүүлэлт 2026 он хүртэл 3,5 хувиар өснө гэж таамагласан байна. АНУ-ын Техас мужид 1974 оноос хойш тасралтгүй болж байгаа олон улсын хөдрөгийн их наадамд гадаад дотоодын 40000 орчим хүн (зөвхөн АНУ-д гэхэд л 3.3 сая хөдрөг урлаачид байдаг), 1000 гаран үйлдвэрлэгчид оролцож, 550 гаруй сургалт, илтгэлүүд 10 өдрийн турш явагддаг байна (Quilt, INC 2024). Энэ мэтчилэн дэлхийн өнцөг булан бүрд сонирхогчид, уран бүтээлчид, үйлдвэрлэгчид зэрэг оролцсон нийгмийн байгууллагуудын зохион байгуулдаг хөдрөгийн үзэсгэлэн арга хэмжээ байнга болж байдаг юм. Жишээлбэл, Япон улсад жил бүр зохиогддог “The Tokyo Great Quilt Festival” –д жил бүр 100,000-150,000 орчим жуулчид очдог байна.

Манай улсын хувьд хөдрөгийн төлөөлөл болохуйц эртний олдвор, бүтээлүүд байгаа хэдий ч тэдгээрийг зүйлчилж ангилаагүйн улмаас тодорхой бус байдаг. Харин хөдрөгийг шинж чанарын хувьд, даавуун урлалын нэгэн төрөл болохын хувьд зээгт наамлын урлалтай холбож үзвэл нэлээдгүй судалгаа, ном хэвлэл байдгаас Ч.Сонгино “Монгол эмэгтэйн уран үйл” (1989), Д.Гангаа, Ү.Дашням “Торгон зураг” (2000), Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музейгээс эрхлэн гаргасан “Торгонд амилсан шүтээн урлаг” (2022) каталог, зэргийг дурдаж болно. Хөдрөг урлалын материалд даавуу утас ба бусад чимэглэлийн материалыг ашиглахаас гадна дүрсээ хайчлан зээггүй нөхөөс мэт оёж дүр дүрслэл хийх тохиолдол элбэг байдаг бөгөөд үүнийгээ нөхөөст хөдрөг хэмээн нэрлэдэг.

2004 оноос хойш манай улсад орчин цагийн хөдрөгийн анхны сургалтын төв, хувиараа сургагч багш нар үйл ажиллагаа явуулж эхэлсэн. Ингэсээр хөдрөг нь хөгжлийн хувьд олон улсын жишигт дөхөж, сонирхогчид хүрээгээ тэлж, улмаар сургалт, гарын авлага зэрэг гарч, хичээлийн хөтөлбөрт заавал судлах сэдэв болон тусгагджээ. Анхны гарын авлага Э.Цэцгээ, Б.Шийлэгмаа нарын “Даавуун урлал” ном 2017 онд гарч байв.

Судалгааны арга зүй

Энэ судалгаанд онолын судалгааны аргачлалын дагуу тухайн анхдагч нэгж эх сурвалжаа олж тогтоон, харьцуулж ангилан, шаардлагатай гэж үзвэл холбогдох музейн эрдэм шинжилгээний ажилтнаас нэмэлт мэдээлэл авч, биетээр дэлгэрэнгүй үзэж, зургийг, холбогдох мэдээллийг цуглуулж харьцуулан үзэв. Зарим олдворууд болон одоо хэрэглэгдэж буй төлөөлөл болох бүтээлүүдийн талаар холбогдох хүмүүсээс ярилцлага авч анализ хийх зэргээр ажиллалаа.

Судалгааны үр дүн

Хөдрөг гэдэг нь латин хэлний “culcita” буюу доторлох, зөөллөх, гудас хавах гэсэн үгээс үүсэлтэй. Монгол хэлний хөдрөх гэсэн үйл үгнээс хөдрөг (Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь. 2024.01.21) гэсэн нэр үг үүсгэн нэрлэгдсэн. Зарим улсад хөдрөгийг нөмрөх, хучих эсвэл хөнжил гэдэг үгээр нэрлэдэг бол ихэнх улс орон шууд хөнжил эсвэл даавуун зүймэл гэсэн утгаар нь нэрлэдэг. Жишээ нь, англи хэлэнд “quilt” хөнжил, орос хэлэнд “квилт, одело” эсвэл хөдрөг нь зүйж хийсэн арга барилтай бол монголоор зүймэл, англиар “patchwork”, оросоор “лоскутное шитье, пэчворк” зэргээр нэрлэдэг. Учир нь зарим хөдрөг нь огт зүйдэлгүй зөвхөн ширж хийсэн байдаг бол зарим хөдрөг нь нөхмөл дүрслэлтэй эсвэл хатгамалтай зэрэг улс орон бүр өөр өөрийн онцлогийг хадгалсан төрөл бүрийн хөдрөг хийж хөгжүүлэн өнөөдрийг хүрчээ. Бид олон улсын жишгийн дагуу хөдрөг хэмээх ерөнхий нэршлийн дор зүймэл хөдрөг, нөхмөл хөдрөг, хатгамалт хөдрөг, ширмэл хөдрөг (хөдрөгт ширмэл гэдэг нэршил голдуу оёдлын машинаар ойрхон хээ гаргаж, ширж оён, давхарлаасаа бэхжүүлэхээс гадна давхар өнгө үзэмжтэй харагдуулах ач холбогдолтой байдаг. Ширж оёх гэдэг үйлийг зөвхөн эсгий ширэхэд хэрэглэх нь явцуу мэт) зэргийг авч үздэг. Хэдийгээр хөдрөг хэмээх нэршил нь үүсмэл боловч олон нийтэд энэ нэрээр түгэн дэлгэрч, өнөөдрийг хүрсэн байна. 2008 оны үе хүртэл квилт хэмээн шууд гадаад үгээр хэлээд зогсохгүй холбогдох арга зүйн нэр нэршлүүд нь ч гадаад үгээр байсныг “Даавуун урлал” номд бүх нэр нэршил үгсийг тохирох монгол хэлний үг рүү хөрвүүлэн буулгасан болно.

Хөдрөг нь 2-3 давхар бүхий өнгө, дотор эсвэл дунд нь хөвөн, зулхай зулж, хавж оёсон нэг төрлийн даавуун ширмэл юм. Олон мянган жилийн өмнөөс хүмүүс хувцас, хучлага зэргийг ийнхүү олон даавуу давхарлаж хийж хэрэглэдэг байсан нь даарч бээрэхээс сэргийлэхийн зэрэгцээ дулаанаа удаан хадгалах гэсэн хэрэгцээндээ тулгуурлаж хийдэг байжээ. Хөдрөгийн өнгөн хэсгийг ямар аргаар хийж байгаагаас хамаараад ширмэл, зүймэл, чигжээ, нөхмөл гэх мэт ангилж болдог. Хөдрөг нь хэрэглэгдэж буй байдлаасаа болж дунд нь зулхайтай болон зулхайгүй хийгддэг. Энэ нь газар зүйн байрлал, цаг агаар, зан заншил, зориулалт зэргээс хамаарч байсан.

Манай улсын эртний хөдрөгийн төлөөллүүд нь бараг бүгд дундаа зулхайгүй, өнгө тал нь зүйгдсэн ар тал нь цулгуй, хамтад нь ширж оёдоггүй, шашны нэг төрлийн эдлэл болж өнөөдөр ч тэр эртний өв соёл, урлахуйн аргачлал, утга агуулгаараа хийгдэж хэрэглэгдэж байгаа. Харин орчин цагийн хөдрөгийн нийтлэг арга болох дундаа зулхай ашигладаг аргууд нь ХХ зууны эхээр хийгдэж эхэлсэн байна.

Хөдрөгийн зүймэл төрлийн анхны олдвор нь Юань гүрний үед хийгдсэн хатгамал бүхий зүймэл торгон бүтээлэг байдаг. Тухайн цаг үеийн олдворууд ихэвчлэн дээрээ хатгамалтай байдаг. Улмаар энэ уламжлал тасарч буддизмын үед дан зүймэл хэсгүүдээс бүрдсэн шашны хэрэглэл болсон.

XIX зууны үед хийгдсэн зүймэл бүтээлүүдэд дахин хатгамал, нөхмөл, зээгт наамал зэргийг ашиглаж ирсэн байна. Зүймэл хөдрөгийн өөр нэг хувилбар нь энхрий хүүхдийн зүймэл баривч юм. Энэхүү баривч нь хүүхдээ муу зүйл, өвчин зовлон, осол эндэгдлээс хамгаалах зан үйлтэй холбоотойгоор одоог хүртэл уламжлагдан хэрэглэгдэж байна.

Түүнчлэн зүү ороож хатгасан зүймэл хөдрөгийн уран нарийн хийцтэй эртний нэгэн олдвор Юань гүрний үед бүтээгдсэн байдаг нь зүйх аргачлалыг монгол урчууд тавьсан байх боломжтой юм. Энэ судалгаанд ялангуяа зүйж хийгдсэн хөдрөгийн олдворуудыг түлхүү авч үзсэн нь хийгдэх арга барилын дотроос зүйж хийх аргачлал нь хамгийн их дэлгэрсэн байдагтай холбоотой.

Одоогоор олдсон түүхэн олдворуудын шинж байдалд тулгуурлан монгол хөдрөгийн хөгжлийг дараах байдлаар ангилан судлах боломжтой.

- НТӨ III-I зууны үе буюу Хүннүгийн үе
- XIII зууны үе буюу хатгамалт зүймэл хөдрөгийн шинэ үе
- XVI-XIX зууны үе буюу шашны хэрэглээнд дэлгэрсэн үе



*Зураг 2. Хүннү ширмэл НТӨ III-I зуун.
Эрмитаж музей, Санктпетербург,
Орос*

НТӨ I зуунаас буюу Хүннүгийн үе

Төв аймгийн Батсүмбэр сумын Ноён уулан дахь хүннүгийн язгууртны булшнаас илэрсэн зээгт хатгамал бүхий эсгийг даавуугаар өнгөлсөн ширмэл ширдэг манай орны төдийгүй олон улсын хэмжээнд хөдрөгийн анхны олдворт тооцогддог. 1924-1926 онд Ноён уулын 6-р булшнаас олдсон нь бараг бүтнээрээ байсан “маш олон тасархай хэсгүүд байдаг ч 6-р булшны МР-2300 олдвор нь бараг бүтэн байсан” (Елихина.Ю.И. 2017, 73) юм.

Энэхүү ширмэл нь хөдрөгийн үндсэн шинж чанар болох давхарлага байдал, ширмэл байдал, нөхмөл дүрслэлүүд зэргээрээ анхны олдворт тооцогддог байна.

Тухайн үеийн эдгээр ширмэл хөдрөгүүд нь бүгд хоорондоо ижил төстэй нэг арга барилаар хийгддэг байсан нь түгээмэл хэрэглэгдэж байсан болох талтай. Бид хүннү ширмэлээ ганцхан эсгий ширмэлийн олдвор гэдэг талаас нь судалж байна. Уг ширмэлийг нарийвчлан үзэхэд, тухайн нийгэм, цаг үеийн олон төрлийн гар урлалын нэгдмэл болж өгдөг бөгөөд дэлгэрэнгүй судлах шаардлагатай гэсэн дүгнэлтэд хүрч байна.

XIII зууны үе буюу хатгамалт зүймэл хөдрөгийн шинэ үе

Энэ үед хөдрөгийн хамгийн чухал аргачлал болох зүйж урлах аргын эх тавигдсан болох нь тухайн цаг үеийн олдворуудаас харж болдог. Үнэтэй торгонуудыг ижил хэмжээгээр дөрвөлжин эсгэж, зүйдэл бүр дээр зүү ороох оёдлоор маш гоёмсог хатгамлыг алтан утсаар хийдэг байсан нь ямархуу үнэ цэнтэйг нь илтгээд зогсохгүй ихэс дээдэс хааны ордонд шашны хэрэглэл болгож байсан гэж үздэг. Энэ үеийн ихэнх олдворууд нь Юань гүрний үед хамаарагдаж байгааг онцлон үзвэл, Хубилай хаан бурхны шашныг бусад шашнаас хөхиүлэн дэмжиж, дэлгэрүүлж байсантай холбоотой. XIII зууны үеийн Юань гүрний ордны уран хатгамал, хувцас эдлэлд ихээхэн үүрэг гүйцэтгэсэн хүн бол Хубилай хааны хатан Чимбай (Цэвэр хатан, Чаби

зэрэг нэрээр тухайн үеийн судар бичгүүдэд нэрлэгдэн үлдсэн байдаг) юм. Түүний сэтгэж хийсэн, зохион бүтээсэн малгайны саравч, ууж хэлбэрийн оноотой дээл, арвич хямгач зангаас нь улбаалан дахин ашиглаж хийсэн торго зэргүүд нь тухайн цаг үеийн судар бичигт тэмдэглэгдсэн үлдсэн байдаг байна (Моррис Россabi 2011, 81,82). Чаби хатны арвич хямгач занг Юань гүрний судруудад ихэд шоолонгуй өнгө аясаар бичсэн тухай эх сурвалжуудад дурдсан байна. Тэрээр буддын шашныг ихэд шүтэж дээдэлдэг байсан юм. Тухайн үеийн бурхан тахилд хэрэглэдэг байсан эдгээр эдлэлүүдийг зүйж хийхдээ маш нарийн чимхлүүр хатгамлаар чимэглэдэг байсан. Жишээлбэл, *Зураг 3*–т байгаа зүйдэл бүр дээрх цэцгэн хатгамлыг алтан утсаар зүү ороож оёсон байдаг нь монгол хүн хийсэн байхыг үгүйсгэхгүй.



*Зураг 3. Торгон зүймэл, XIII зуун Юань гүрэн.
Метрополитын урлагийн музей. АНУ*

Учир нь тэр үеийн хятад хатгамлуудад зүү ороох оёдол ашигладаггүй байсныг хятад хатгамлын талаар 25 жилийн судалгаа хийсэн уран хатгамалч Бертин-Гест Жозен (2007) номноос болон тухайн үед хамаарах музейн үзмэрүүдээс харж болно. Түүнчлэн, уг номд Юань гүрний үеийн хатгамлуудын талаарх судалгаа байхгүй бөгөөд XIII зуунаас эхлэн хятад хатгамлууд эрс хөгжиж дүрслэл, өнгө, төрөл гэх мэт үзүүлэлтүүд нь гайхалтай сайжирсан талаар дурддаг. Ер нь хятад оёдлын зүйл болон хатгамлын талаар цахим музейн олдворуудыг үзэхэд Юань улсын үеийн хатгамал гэж нэрлэн дэлгэгдсэн нь маш ховор байдаг нь их гүрний соёлын бодлого байж болох талтай. Дээрх Юань гүрний үед хамаарах зүймэл олдворын хатгамал дээрх зүү ороосон оёдол нь бага зэрэг сийрэгдүү, хатгаас хоорондын зай нягт биш байдаг нь хуучны монгол хатгамлууд дээрх зүү ороосон оёдолтой төстэй байна. Зүйдэл тус бүрийг зүйсэн аргачлал нь оёдлын залгаасыг хагалж дэлгэх аргаар хийгдсэн, зүйдэл бүрийн өнцгүүд эсрэгцэн зөрүү үгүй нийлж оёгдсон зэрэг нь өнөөдөр ч түгээмэл ашигладаг аргын нэг юм.

Энэ хэсэгт өөр нэг нарийн хийцтэй бүтээл нь XIII-XIV зууны үед хамаарах нөмрөг юм (*Зураг 4*). Үнэтэй торгон материал дээр зүү ороож хатгасан хүзүүндээ углаж тогтоодог нөмрөг юм. Энэ нөмрөгийн онцлог нь зүйдлээрээ таван нүдэн хээг гарган дүрсэлж зүйдэл бүр дээрээ цэцэг, угалзан хээг хатгасан байна.

Юань гүрний үед хамаарах бас нэг олдвор нь дэрний зүймэл уут юм. Энэ олдворын онцлог нь гол хэсгийн 2 зүйдэл дээр энгийн хатгамал хатгаж, эмжээр хэсэг дээр хээлсэн хатгамалтай байна. Эдгээр олдворуудаас харахад, тэр үед зүйж хийх арга нь нэлээд дэлгэрсэн байж болохоос гадна, тухайн үеийн ордны гар

урлалд ихээхэн тусгалаа олж байжээ. Зарим дөрвөлжин зүйдэл нь хэд хэдэн өнгө дагуу маш жижиг зүүдлүүдээс бүтдэг бөгөөд торгоны өөдсүүдийг бага гэлтгүй бүгдийг ашиглаж байсан нь олдворууд дээр харагддаг.



Зураг 4.

*Нөмрөг XIII-XIV зуун
Азийн урлагийн музей. Сан Франциско*



Зураг 5.

*Дэрний уут XIII зуун Юань гүрэн.
Метрополитын урлагийн музей. АНУ*

XVI-XIX зууны үе буюу хэрэглээнд дэлгэрсэн үе

Энэ үеийн олдворууд нь ихэвчлэн шашны холбогдолтой байдаг. Бурхны өмнөх тахилын ширээ болон номын уншлагын ширээн дээр одоо ч түгээмэл харагддаг олон өнгийн торгыг өнгө уусгаж шатарчлан зүйсэн дүрслэлтэй бүтээлэг юм. Гандан хийдийн лам н.Гансүх, Б.Дашдэмбэрэл нараас хэрэглээ зориулалтын талаар тодруулахад: “Энэ зүйлийг төвөдөөр “Дингов” гэж нэрлэдэг. Бид бурхны ширээ болон номын ширээгээ бүтээдэг. Бас түй өргөхдөө нөмөрч зогсдог. Заримдаа бурхны эдлэл зэмсгээ бүтээдэг” гэж хариулсан. Харин энэ зүйлийн учир бэлгэдлийн талаар бурханч лам М.Эрдэмбилэг ярихдаа, “Бурхан багшид өргөл өгье хэмээвч өгөх зүйл нэгээхэн ч үгүй хоёр үгээгүй ядуу хүн өөрсдийн тэр гэхийн аргагүй нөхсөн халхавч даавуугаа өргөл болгосонд түүний шавь нар ийм муухай зүйл авах хэрэггүй гэсэнд Бурхан багш энэрэнгүй өгөөмөр сэтгэлээр өргөсөн зүйл бол ариун зүйл хэмээн түүгээр биеэ ороосонд даруй гайхалтай сайхан нөмрөг болсон гэдэг”. XVI-XIX зууны үед хамаарах хамгийн нарийн ур хийцтэй бүтээлүүд нь одоогоор Богд хааны ордон музейд хадгалагдаж байна. Тус музейн эрдэм шинжилгээний ажилтнаас тодруулахад, бурхны бүтээлэг юм уу хөшиг байх боломжтой гэж хариулав. *Зураг 6* дээрх хас хээ бүхий голын дүрслэл нь 1,5 см тэг дөрвөлжин 1520 ш торгоны зүйдлийг маш цэвэрхэн нэг бүрчлэн зүйж оёсон байна. Энэ мэтчилэн нөхмөл, хатгамал, зүймэл хэд хэдэн хөдрөгийн үзмэрүүд байгаа нь тухайн цаг үедээ хөгжлийн өндөр түвшинд хүрч байсны тод жишээ болно.

Нэлээд хожуу үеийн болон одоо хэрэглэгдэж байгаа зүймэл бүтээлүүдийг төв Гандантэгчинлэн хийд болон бүхий л сүм хийдийн газруудад хэрэглэгдэж буй байдлыг зургаар үзүүллээ.



*Зураг 6. Бурхны хөшиг. XIX зуун.
Богд хааны ордон музей. Монгол*



*Зураг 7. Дингов. 2020 он.
Төв Гандантэгчилэн хийд*

Мөн энд зүйж хийх технологи бүхий энхрий хүүхдийн зүймэл баривчийг дурьдах нь зүйтэй. Монголчууд эртнээс үр хүүхэд тогтохгүй байх болон өвчин ороомтгой үед хүүхдийнхээ хүйсийг нь нууж хувцаслах, олон нөхөөст ба буруу энгэртэй дээл хувцас хийж өмсгөдөг уламжлалтай байжээ (Зураг 8,9). Энэ зан үйл нь нэлээд эртнийх боловч яг хэзээнээс эхэлсэн нь тодорхой бус байдаг нь холбогдох олдвор одоогоор олодоггүй байгаатай холбоотой. Гэсэн хэдий ч үүнийг судлах шаардлагатай бөгөөд ялангуяа одоо байгаа хөдрөгт хамаарах хийц загвар бүхий олдворуудад судалгаа хийх шаардлагатай байна.




*Зураг 8. Энхрий хүүхдийн баривч.
XIX зуун. Монголын үндэсний музей*



*Зураг 9. Энхэр хүүхдийн дээл. XX зуун.
Хэнтий аймгийн музей*

Энхрий хүүхэддээ зүймэл баривч хийх зан үйл одоо ч бидэнд хадгалагдаж байгааг зарим хувцас үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүнээс харж болно. Зүймэл хувцас хэрэглэл нь түгээмэл төдийгүй бас ширмэл хувцаснууд үйлдвэрлэлд нэвтэрч, түүн дээрх ширмэлийн хээ загвар улам боловсронгуй болсоор байна (Зураг 10).



Зураг 10. Э.Цэцэгэ “Газрын цэнэг” Хэмжээ: 152см х 298см, 2023он

Хэлэлцүүлэг

Өдгөө ихэнх улс оронд тухайн улсад хамаарах хөдрөгийн түүхэн судалгаа байдаг бол манай улсад энэ чиглэлийн судалгаа одоогоор дутмаг байна. Эртний түүхэн олдвор, дурсгал, баримт материал ихтэй манай улсын хувьд хөдрөгийн түүхэн хөгжлийн судалгаа хийх бүрэн боломжтой. Шинэ үеийн хөдрөг нь манай улсад сүүлийн 20-оод жилийн турш хөгжиж байгаа ч тархалт удаашралттай, энгийн хэрэглээний урлал төдий байгаа нь энэ салбарт мэргэжлийн уран бүтээлчид өөрсдийгөө сорьж үзэхгүй байгаатай холбоотой. Иймээс энэ удаагийн судалгаагаар монгол хөдрөг судлалын эхлэлийг тавьж, улмаар уламжлалт гар урлал, өв соёлын нэг мөн болохыг нь тодорхойлон, үндэсний өв соёлоо сурталчлах, түгээн дэлгэрүүлэхэд ихээхэн хувь нэмэр оруулах бололцоотой юм. Үүний тулд, юуны өмнө эрэн сурвалжилж, холбогдох дурсгалуудыг бүртгэж баримтжуулах, төрөлжүүлэх, урласан арга ажиллагаа, хийц зохиомж, материалыг судлан таних, тодорхойлох зэрэг ажлуудаас судалгаагаа эхлэх нь зүйтэй гэж үзэв. Үүнд:

- Хөдрөг урлалын түүхэн судалгаа хийж, холбогдох олдвор, дурсгалуудыг илрүүлэн, тэдгээрийг урлан бүтээсэн арга ажиллагаа, ур хийц, хэрэглээ зэргийг тодруулан төрөлжүүлэх
- Музей болон сүм хийдүүдэд хадгалагдаж байгаа холбогдох эх сурвалжуудыг олж тогтоон, баримтжуулж он цагийн үечлэлд оруулах
- Зүйж хийгдсэн арга барил, ур хийц, өнгөний болон материалын зохиомж, хэрэглэсэн материал гэх мэт элементүүдээр нь шинжиж, хувьсан хөгжиж ирснийг тодорхойлох зэрэг орно.

Дүгнэлт

Монгол хөдрөг нь түүхийн хугацааны туршид тасралтгүй өвлөгдөн уламжлагдаж, үндсэн агуулга, хэлбэрээ алдалгүй хөгжсөөр өнөө цаг үед ирсэн байна. Ялангуяа бусад улс оронтой харьцуулан харахад, зүйх аргачлалын эртний түүхтэйг харуулахын зэрэгцээ хөдрөг нь соёлын өвд тооцогдох чухал уламжлалт урлал юм гэдгийг тодорхойлж болохоор байна.

Түүнчлэн хүннү ширмэл нь ганц эсгий урлал биш зээгт урлал, хөдрөг урлалын олдвор юм гэж үзэн, эдгээр нь хэрхэн салаалан хөгжсөн байж болох график зураглал гаргаж, энэ чиглэлүүдээр нэмэлт судалгаа хийж болох санааг гаргаж байна.

Манай улс хөдрөг урлалын тодорхой түүхтэй, энэ урлалын гарал үүсэлд үнэтэй хувь нэмэр оруулсан байх боломжтой байгаа нь монгол хөдрөг судлалыг судалж хөгжүүлэхэд ихээхэн нөөц, бололцоо, эх сурвалжууд байна гэж үзэж байна.

Монгол хөдрөг нь түүхэн болон хөгжлийн үеүдэд ангилагдан хуваагдаж, тухайн цаг үеийнхээ өвөрмөц онцлог, арга барилыг өөртөө шингээн, энгийн дэрнээс энхрий хүүхдийн баривч хүртэл хэрэглээнд оршиж, зан үйл соёлын нэгэн илэрхийлэл болж байна.

Хөдрөгийг олон улсад хэрхэн хөгжиж байгааг жишиг болгон өөрийн улсын хөдрөгийн хөгжил, сургалт, судалгаанд түлхүү анхаарч, энэ чиглэлээр залуу үеийг бэлтгэх, уран бүтээлчдийг бодлогоор дэмжиж хөгжүүлэх хэрэгтэй байна.

Дээрх судалгааны үр дүнг анхааран үзэж, хөдрөгийг бусад соёлын өвийн адил хэмжээнд үнэлж, соёл урлагийн хөгжлийн бодлого боловсруулалтад монгол хөдрөгийг цаашид хөгжүүлэх, олон улсад сурталчлан таниулах, холбогдох үзэсгэлэн арга хэмжээг дэмжих, олон улсын хэмжээнд өрсөлдөхүйц уран бүтээлчдийг мэргэжлийн байгууллагуудын тусламжтайгаар бэлтгэх нь зүйтэй юм.

Ашигласан материалын жагсаалт

Бертин-Гест Жозен. 2007. *Традиционная китайская вышивка*. Москва.

Елихина Ю.И. 2017. *Эрмитаж дахь ноён уулын эрдэнэс*. Улаанбаатар.

Монгол Улсын Шинжлэх ухааны академи. 2008. *Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь Т-Х*. Улаанбаатар: Бемби сан.

Моррис Россаби. 2011. *Хубилай хаан түүний амьдрал цаг үе*. Улаанбаатар: Содпресс.

Нямбуу, Х. 2002. *Монгол хувцасны түүх*. Улаанбаатар: Адмон.

Цэцгээ. Э., Шийлэгмаа. Б. 2017. *Даавуун урлал*. Улаанбаатар: Мөнхийн үсэг.

Creative Publishing International. 2010. *The Quilting Bible, 3rd Edition: The Complete Photo Guide to Machine Quilting*. USA.

Цахим эх сурвалж:

Баярсайхан, У. 2020. “XX зууны үеийн энхрий хүүхдийн дээл.” 2020.07.30. Монголын үндэсний олон нийтийн телевизийн нэвтрүүлэг. <https://www.mnb>.

mn/i/213107

Хэнтий музей. 2020. “Энхрий хүүхдийн дээл.” Facebook, 2024.01.21. <https://www.facebook.com/photo.php?fbid=685385948954694&set=pb.100024498844336.-2207520000&type=3>.

Catalogue of Egyptian Antiquities in the British Museum' V Early Dynastic Objects. 1980. www.britishmuseum.org. 2024.01.21. https://www.britishmuseum.org/collection/object/Y_EA37996.

Carolyn Ducey, International Quilt Study Center. 2011. “Quilt History Timeline, Pre-History – 1800.” www.web.archive.org. 2024.01.21. https://web.archive.org/web/20120404031517/http://www.quiltstudy.org/file_download/5875deb7-a0b1-4cc3-b7d7-e0ff5036517b

Cindy Joan Brick. 2019. s.v. “the-quilt-revival.” *Encyclopædia Britannica*. <https://www.britannica.com/art/quilting/The-quilt-revival>.

Jannik Lindner. 2022. “GITNUX Report 2022.” *Gitnux (blog)*. 2024.01.21. <https://blog.gitnux.com/quilt-industry-statistics/>.

Quilt. 2024. “Quilt INC About us 2024.” <https://www.quilts.com/quilt-festival/>

Ярилцлага:

н.Гансүх, Б.Дашдэмбэрэл нартай хийсэн ярилцлага. Улаанбаатар хот: Төв Гандан хийдийн Батцагаан дуган, 2023.11.13.

М.Эрдэмбилэг (бурханч лам)-тэй хийсэн ярилцлага. Улаанбаатар хот: Тайж уулын бэл, Нүүдэлчин наадам, 2024.08.18.